



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
 ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
 ТУШААЛ**

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 8/27

Шивээговь сум

**Т.Цэдэнбалжиртай байгуулсан хөдөлмөрийн  
 гэрээг дуусгавар болгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.9, 79 дүгээр зүйлийн 79.1, 110 дугаар зүйлийн 110.3, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дугаар “Журам батлах тухай” тушаалын хавсралт “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын 1.1, 2.8.1 дэхь заалт, ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гэрээт жижүүр Төмөрмөнхийн Цэдэнбалжирын ажлаас чөлөөлөгдөхөөр гаргасан хүсэлтийг харгалзан 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосугай.

2. Т.Цэдэнбалжирын хариуцаж байсан эд хөрөнгийг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Д.Отгонбаатар

(Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Г.Дашдэлэг

(Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч)

Б.Мөнхцэцэг


(Нярав)

3. Ажлыг хугацаанд нь зохион байгуулж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг комиссын дарга (Д.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

4. Т.Цэдэнбалжирт ажилласан хугацааны мөнгийг бодож олгохыг нягтлан бодогч (Б.Энхмаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
 ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ЦЭРЭНДОРЖ



422220098